

**НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ
АЭРОДРОМ, АГААРЫН НАВИГАЦИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН**

2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай ИНЕГ-ын дэд даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталсан 32/20 тоот удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны нисэхийн аюулгүй ажиллагаа хариуцсан менежер П.Батсайхан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн болон ОУИНБ протокол асуултын хүрээнд тус хэлтэс үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, холбогдох стандартыг мөрдөж ажилласан эсэхийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, хариуцсан албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Байцаагч нарын хийж буй ажлын ачааллын тэгш бус байдал нь хэлтсийн нэгдмэл бүтцээс шалтгаалан ил харагдахгүй байна. Иймээс ИНЕГ-ын даргаас шилжигдсэн эрхийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадамж Аэродромын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналтын чиглэлд дутмаг байна.

Эрх шилжүүлэх гэрээг тухайн мэргэжлийн, тухайн чиглэл хариуцсан байцаагч бүрт бүрэн шилжүүлэх нь зүйтэй байна.

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг дахин боловсруулах зүйтэй.

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн бүх байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод

- Иргэний нисэхийн тухай хууль"-ийн 44.2 дугаар заалт,
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.24.заалт

тус бүрийг тусгасан нэмэлт өөрчлөлтийг оруулах шаардлагатай.

Мөн дээрх албан тушаалын тодорхойлолтын Мэргэшил хүснэгтэд аль сургалтын байгууллагын ямар чиглэлийн сургалтад хэр хугацаагаар хамрагдсан байхыг тодорхой бичих шаардлагатай байна.

ОУИНБ-ын аудит шалгалтаар илэрсэн асуудлуудыг хэрэгжүүлсэн байдлаа тус байгууллагын <https://soa.icao.int/CMAOnline/Car.aspx> хаягаар онлайнаар хариулах ажлыг шуурхайлах шаардлагатай гэж дүгнэж байна

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус албанд 6 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА